

Сэрээтэрийн Лхүндэв /1934-2019/

Монголын арьс өнгөний эмч нарын нийгэмлэгийн дарга, Арьс судлал сэтгүүлийн орлогч эрхлэгч, Анагаах ухааны доктор, клиникийн профессор

С.Лхүндэв нь 1934 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Ховд аймгийн Чандмань суманд "Антын цагаан арал" гэдэг газар төрсөн. 1942 онд Чандмань сумын бага сургууль, 1946 онд Ховд аймгийн 10 жилийн сургуульд орж 1952 онд төгссөн. Мөн ондоо МУИС-ийн анагаах ухааны факультетад элсэн орж 1957 онд төгсөж хүний их эмчийн мэргэжил эзэмшсэн.

С.Лхүндэв нь :

1957-1958 онд Говь-Алтай аймгийн Цээл сумын хүний их эмчийн салбарт анхны эрхлэгч,

1958-1961 онд Говь-Алтай аймгийн эрүүлжүүлэх 3-р отрядын дарга

1961 оны 03 дугаар сарын 1-нээс 08 дугаар сарын 01 хүртэл Улаанбаатар хотын Арьс өнгөний больницид их эмч

1961 оны 08 дугаар сарын 01-нээс Улаанбаатар хотын Анагаах ухааны дунд сургуульд багш,

1962 оны 03 дугаар сарын 15-наас ШУА-ийн Анагаах ухааны хүрээлэнд эрдэм шинжилгээний ажилтанаар 1968 он хүртэл ажилласан.

Энэ хугацаанд АУДЭС, АУДyC-д багш, Арьс өнгөний больницид тасгийн эрхлэгчийг ба Сайд нарын эмнэлэгт эмчээр хавсран ажиллаж байсан.

1967 онд Анагаах ухааны докторын зэрэг хамгаалсан

1968-1969 онд Улаанбаатар хотын нэгдсэн эмнэлгийн эмнэлэг эрхэлсэн орлогч дарга

1969-1975 онд Дархан хотын Эрүүлийг хамгаалахын газрын дарга

1975-1976 онд Арьс өнгөний улсын диспансерт зөвлөх эмч

1976-1980 онд Эрүүлийг хамгаалах яамны эрдэмийн зөвлөлд эрдэмтэн нарийн бичгийн дарга, Монголын анагаах ухаан сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга

1980 оноос АӨЭСНТөвд их эмч, тасгийн эрхлэгч, зөвлөх эмчээр ажиллаж байсан.

“Арьсны мөөгөнцөрт өвчин” номыг Ч.Долгорын хамт анх бичиж гаргасан. Сүүлийн хэвлэлийг бие дааж хэвлүүлсэн. Арьсны мөөгөнцөрт өвчин ба идээт өвчнөөс

урьдчилан сэргийлье товхимолууд, “Арьсны өвчнийг ялган оношлох-сувилахуйн сурах” зэргийг Орос хэлнээс Монгол хэлд орчуулсан. Удаа дараагийн арьс өнгөний эмч нарын онол практикийн бага хурлын материалуудыг эмхэтгэлцсэн зэрэг эрдэм шинжилгээ судалгааны бүтээл, өгүүлэл, илтгэл 10 гаруй бүтээлүүдтэй. С.Лхүндэв нь эдгээр бүтээлээс гадна эмч нарын зэргийн шалгалт резинтурын сургалт, доктор, магистрын хамгаалалтанд зохих шаардлагын дагуу тогтмол оролцож ирсэн сурган хүмүүжүүлэгч юм.

С.Лхүндэв нь 1976 онд ЗХУ-ын Москва хотод Олон улсын патентын дээд курс төгссөн патентын мэргэжилтэй. 1976-1978 оны ШБОС-ын үзэсгэлэнгээс хүрэл, мөнгөн медаль авсан.

Арьс гоо заслын мэргэжлийн зөвлөлийн гишүүнээр анх байгуулагдсан цагаас нь тогтмол ажиллаж байсан. Эмч нарын мэргэжил дээшлүүлэхэд тогтмол оролцож зарим үед биеэр тусалж ирсэн. Арьсны өвчнүүдийн өвчлөлт, оношлогоо, эмчилгээний орчин үеийн аргад эмч нарыг цаг алдалгүй сургахад өөрийн хүч хөдөлмөр цаг завыг зарцуулж ирсэн эрдэмтэн.

1961 онд Хөдөлмөрийн хүндт медаль

1976 онд Эрүүлийг хамгаалах яамны жуух

2001 онд Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан

“Ардын хувьсгалын 50,60,70” жилийн ойн медаль

Эрүүлийг хамгаалахын 80 жилийн ойн медаль

2001 онд Алтан гадас одонгоор шагнагдсан

1961-1996 он хүртэл тус нийгэмлэгийн нарийн бичгийн дарга, тэргүүлэгчээр ажиллаж байгаад 1996 оноос өнөөдрийг хүртэл Арьс өнгөний нийгэмлэгийн даргаар тус тус ажиллаж байна.

Эрдэм шинжилгээ судалгааны ажлын хэсгээс:

Хуйхны өнгөц мөөгөнцөрт өвчнүүдийг 4% эпилины пластыраар эмчлэх сэдвийг судлах аргачилал, удирдах багшийн хамт батлуулан 3 жил ажилласны дараа ШУА-ийн тэргүүлэгчдийн хурлаар горилогчоор батлагдаж 1 сэдэвт зохиолын нх нооргын хамт эрдэм шинжилгээний томилолтоор ЦКВИ-д 2 сар ажиллан профессор А.М.Ариевичийн удирдлагын дор эх зохиолуудыг ашиглан диссертацийн эх бичлэгийг бичин шалгуулан зөвшөөрөгдөн 1967 он хүртэл минимуммын шалгалтыг өгч 1967-10-04-нд Улаанбаатар хотноо эрдмийн зэргийг амжилттай хамгаалсан юм. Уг зохиолд хуйхны өнгөц мөөгөнцөрт өвчнүүдийн клиникийн онцлогыг судлахад өвчлөлтөөр 1-рт хяргагч үлд, 2-рт бужуу үлд орж байсан бол 3-рт хожгор үлд орж байжээ.

Тэгвэл өнөөдөр 1-рт бужуу үлд, 2-рт хяргагч үлд орж хожгор үлд бүр мөсөн устсан байна

Хуйхны өнгөц мөөгөнцөрт өвчнүүдийн эмчилгээнд 1950-1960-аад оны үед голомтын үсийг уутанцрын хамт унагаах /эпиляц/ арга эмчилгээний үр дүнд хүрэхэд онцгой ач холбогдолтой байлаа. Ийм учраас ЗХУ-д профессор А.М.Ариевч 4% эпилинийн пластыр үйлдвэрлэн гаргаж практикт нэвтрүүлж байсан үед Ч.Долгор, С.Лхүндэв нар Монголд шинээр үйлдвэрлэн, ЗХУ-ын ЦКВИ-д үйлдвэрлэсэн нь ЗХУ-ынхаас үйлчилгээгээрээ дутуугүйгээс гадна рентген-эпиляцтай харьцуулан судлахад эмчилгээний үр дүн нь рентгенээс дутуугүйгээс гадна хямд, хэрэглэхэд хялбах энгийн болох нь нотлогдсон. Мөн гаж нөлөө үзүүлдэггүй, шинжилгээнд ямарч өөрчлөлт илэрдэггүй болох нь бидний судалгаагаар батлагдсан юм.

С.Лхүндэв нь “Арьс судлал” сэтгүүлийг санаачлагч, үүсгэн байгуулагчдын нэг бөгөөд тус сэтгүүлийн орлогч эрхлэгчээр ажиллаж байна.

Сэрээтэрийн Лхүндэв нь эрүүлийг хамгаалах яаманд ажиллаж байхдаа 1976 онд ЗХУ-ын Сайд нарын Зөвлөлийн нээль, шинэ бүтээлийн улсын хорооны дэргэдэх удирдах ба инженер-техник, эрдэм шинжилгээний ажилтаны нээлт, шинэ бүтээл, оновчтой саналын дээд курст суралцан төгсч патентын мэргэжил эзэмшиж мэргэжил дээшлүүлсэн патентын мэргэжилтэй.

Эрүүлийг хамгаалах яаманд эрүүлийг хамгаалах яамны эрдмийн зөвлөлийн эрдэмтэн нарийн бичгийн дарга, Монголын анагаах ухаан сэтгүүлийн хариуцлагатай нарийн бичгийн дарга, эрдэм шинжилгээний ажлын зохицуулах зөвлөлийн нарийн бичгийн дарга, ЭХЯ-ны социалист уралдааны зөвлөлийн нарийн бичгийн дарга, ЭХЯ-ны нээлт, шинэ бүтээл оновчтой саналын зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг албыг хавсран гүйцэтгэж байсан.

Дээрх зөвлөлүүдийн дарга нь ЭХЯ-ны 1-р орлогч сайд, улсын ариун цэврийн газрын дарга, улсын ариун цэврийн ерөнхий байцаагч профессор Г.Жамба ажиллаж байсан.

Улсын хэмжээгээр зохиогдсон эрүүлийг хамгаалах ШБОС-76, ШБОС-78 үзэсгэлэнг өөрийн биеэр зохион байгуулж ажилласан. Эрүүлийг хамгаалах салбарын хэмжээнд нэг удаад 40-50 орчим бүтээлүүд тавигдаж байсан.

С.Лхүндэв н 1994-1995 оноос эхлэн Л.Пэрэнлэй, Мягмар Алтантуяа нарын хамт Т-идэвхлүүр тималин-мон үйлдвэрлэн клиник туршилтыг дуусган практикт нэвтрүүлэн эмийн бүртгэлд оруулсан. Мөн МУИС-ийн химийн багш Дэмбэрэлсамбуу бусад нөхдийн хамт повидон, хемодин, таймедины уусмалыг мөөгөнцөрт өвчний эмчилгээнд үр дүнтэйгээр хэрэглэж практикт нэвтрүүлсэн.

ШУА-ийн хими-хими технологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Дугаржав, Авид, Байгалмаа нарын хамт ялзмагт шаврыг арьсны мөөгөнцөрт өвчнүүд болон арьсны бусад өвчнүүдийн үед хэрэглэн практикт нэвтрүүлсэн байна.

С.Лхүндэв нь Ялзмагт шавар нь хуйхны өнгөц мөөгөнцөрт өвчнүүдийн үед ялангуяа хар цэг хэлбэрийн хуйхны архаг хяргагч үлдийг эмчлэхэд онцгой ач холбогдолтой байгаагаас гадна хуйх арьсны гүнзгий хяргагч үлдийг эмчлэхэд онцгой үр дүнтэй болохыг тогтоон практикт нэвтрүүлээд байна.

Манай АӨЭСНТөвд ЗХУ-аас урилгаар ирж ажиллаж байсан Анагаах ухааны доктор В.А.Харитоновын хамт хөлийн хумсны гэмтлийг мэс заслын аргаар авч эмчилж байгаа нь үр дүнгээ өгсөөр одоо хүртэл хэрэглэгдсэн хэвээр байна.

Арьсны архаг мөөгөнцөрт өвчнүүдийн эмчилгээнд Мон-тималин, Т-идэвхлүүр зэргийг хэрэглэхэд эмчилгээний үр дүн сайтай байгааг ч судалсан байна.

Мөн ионжуулсан, мөнгөний коллойд уусмалыг арьсны өвчний эмчилгээнд хэрэглэн практикт нэвтрүүлсэн.